



МОНГОЛ УЛС
САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ
ТОГТООЛ

2015 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 416

Улаанбаатар хот

“Монгол шуудан” ХК-ийн үнэт
цаасны бүртгэлд өөрчлөлт оруулах тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 9 дүгээр зүйл, 63 дугаар зүйлийн 63.1.10, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 06 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаасны бүртгэлийн журам”-ын 7.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:

1. “Монгол шуудан” ХК-ийн нийтэд санал болгон гаргасан энгийн хувьцааны тоог 33,859,363 /гучин гурван сая найман зуун тавин есөн мянга гурван зуун жаран гурав/ ширхэг энгийн хувьцаагаар нэмэгдүүлэн үнэт цаасны бүртгэлд бүртгэн, тус компанийн нийт хувьцааг нэг бүр нь 100 төгрөгийн нэрлэсэн үнэ бүхий 99,586,363 /ерэн есөн сая таван зуун наян зургаан мянга гурван зуун жаран гурав/ ширхэг байхаар үнэт цаасны бүртгэлд өөрчлөлт оруулахыг Үнэт цаасны зохицуулалтын газар /Т.Гандулам/-т үүрэг болгож, хөрөнгийн биржийн жагсаалтад өөрчлөлт оруулахыг “Монголын хөрөнгийн бирж” ХК /М.Болор/, үнэт цаасны төвлөрсөн хадгаламжид бүртгэхийг “ҮЦГТТХТ” ХХК /Ж.Алдаржавхлан/-д тус тус зөвшөөрсүгэй.

2. “Монгол шуудан” ХК-ийн нэмж гаргаж буй хувьцааг олон нийтэд 185 /нэг зуун наян тав/ төгрөгөөс доошгүй үнээр санал болгохыг зөвшөөрсүгэй.

3. Үнэт цаасны зах зээлийн тухай хуулийн 20 дугаар зүйл болон Хорооны 2013 оны 505 дугаар тогтоолоор батлагдсан “Үнэт цаас гаргагчаас мэдээллийг нийтэд тогтмол хүргэх тухай журам”-д заасан мэдээллийг олон нийтэд цаг тухайд нь тогтмол хүргүүлж, хууль тогтоомжоор хүлээсэн үүргээ чанд биелүүлж ажиллахыг “Монгол шуудан” ХК /Ц.Батсайхан/-д үүрэг болгосугай.

4. Тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт шалгалтын газар /Б.Оюунцацрал/, нэгдсэн бүртгэлд бүртгэхийг Бүртгэл зөвшөөрлийн газар /Э.Мөнхбаяр/, олон нийтэд мэдээлэхийг Тамгын газар /П.Алтан-Од/-д тус тус даалгасугай.

ДАРГА



НАРАНТУЯА

001120